



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/33/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 231
танай _____ ны № _____ т

ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Татварын ерөнхий газраас 2025 оныг "Зөвлөн туслагч татварын алба" болгон зарлаж, татвар төлөгчид, олон нийтийн боловсролд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Татварын газарт улс орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, материаллаг бааз суурийг бэхжүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгсэл, машин тоног

6326050290

төхөөрөмж, тавилга эд хогшлыг улс болон нутгийн төсвөөс нийт 295.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a pink rectangular official stamp. The stamp contains the Mongolian text 'МОНГОЛ УЛСЫН АУДИТЫН АГЫН ГЭР' (State Audit Agency of Mongolia) and the name 'Д. БАТЦОГТ' (D. Batcogt) in the center.

Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	44,452.2	27,037.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,324,706.3	1,443,511.9
Нийт хөрөнгийн дүн	1,369,158.5	1,470,549.2
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,369,158.5	1,470,549.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,369,158.5	1,470,549.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,317,983.6	2,430,028.5
Үйл ажиллагааны зардлын дүн	2,363,625.2	2,322,866.8
Үйл ажиллагааны үр дүн	(45,641.6)	107,161.7
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(5,771.0)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(45,641.6)	101,390.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,414,800.0	1,369,158.5
Тайлант оны үр дүн	(45,641.5)	101,390.7
Эцсийн үлдэгдэл	1,369,158.5	1,470,549.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,277,230.6	2,238,405.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,270,193.9	2,236,653.5
Үйл ажиллагааны ЦМГ	7,036.7	1,751.6
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(16,229.9)	(23,600.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(9,193.2)	(21,848.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,041.6	21,848.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,848.4	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,143,522.3	2,114,039.0
Урсгал зардал	2,143,522.3	2,114,039.0
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,143,522.3	2,114,039.0
Улсын төсвөөс санхүүжих	2,143,522.3	2,114,039.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Татварын газар нь эрхэм зорилгоо “Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино” гэж тодорхойлсон.

Татварын албаны үйл ажиллагааны үндсэн зарчим нь Татварын алба нь Татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд Зайлшгүй байх, Тодорхой байх, Шударга байх, Үр ашигтай байх зарчмыг баримтална.

Татварын ерөнхий газраас 2025 оныг “Зөвлөн туслагч татварын алба” болгон зарлаж, татвар төлөгчид, олон нийтийн боловсролд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргаар 83.8 хувьтай үнэлүүлэн, “хэвийн” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Татварын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга;
- Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Татварын газарт улс орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, материаллаг бааз суурийг бэхжүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг улс болон нутгийн төсвөөс нийт 295.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Татварын ерөнхий газраас 2025 оныг “Зөвлөн туслагч татварын алба” болгон зарлаж, татвар төлөгчид, олон нийтийн боловсролд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажилласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 178 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 5.0 сая төгрөгөөс дээш 2,283.6 сая төгрөгийн 28 орлогын, 124.9 сая төгрөгийн 12 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн улирлын урамшууллыг тооцон олгож байгаа ч Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 33 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам”-ыг үндэслэн сар бүрийн улс, аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувиас хамааран 40-50 хувийн урамшууллыг сар бүр авч байна.

Цаашид давхардан олгогдож буй урамшууллын эрх зүйн актыг тодорхой болгох нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 43.9 сая төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад 14.4 сая төгрөгийн 5 алдааг залруулж, залруулагдаагүй 29.5 сая төгрөгийн 1 алдаанд албан шаардлага өгч ажиллалаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 29.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.9 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө

Албан шаардлага

1.Төрийн албан хаагчийн улирлын ажлын дүнгийн урамшуулалтай давхацуулан 13 дахь сарын урамшуулал хэлбэрээр урамшуулал, тэтгэмж олгохгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 4.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар баталгаажуулаагүй	1	4.4			1	4.4	1	4.4				
Газрын төлбөрийн үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлангийн өглөгийн дансанд 19.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн.	1	0.01			1	0.01	1	0.01				
Цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардалд бүртгэсэн.	1	5.8			1	5.8	1	5.8				
Цалингийн зардалтай холбоотой бичилт болон АО-ын НДШ, даатгуулагчийн НДШ бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан.	1	3.1			1	3.1	1	3.1				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулах бичилт хийгээгүй, зардалд бичилт хийж тайлагнасан.	1	1.1			1	10.0	1	10.0				
Дүн	5	14.4			5	14.4	5	14.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын газрын 37 албан хаагчид 13 дахь сарын урамшуулал олгосон.	1	29.5			1	29.5						
Дүн	1	29.5	-	-	1	29.5	-	-				